

## АРДЫН ЭРХТ ТӨРИЙН ДИПЛОМАТ АЛБА, ГАДААД ХАРИЛЦАА: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОРГОН ЭХЛЭЛ

*Д.Уламбаяр*

### 1. Монгол улсын дипломат алба сэргээн байгуулагдсан нь

МАН анхдугаар их хурлын гаргасан шийдвэрийг үндэслэн 1921 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн эвлөлгөөнөөр "...түмэн ард амьтны эрх мэдлийг бадруулахыг бодож, эрх биш гадаадын цаг үеийн хүчнээс ангижирсан бөгөөд зэргэлдээ ардын засагт улсуудтай найрамдах Монгол Ардын засгийн хэргийг Бүгд Түр Ерөнхийлөн Захирах Газрыг байгуулбал зохино"<sup>1</sup> гээд Монгол Ардын Түр Засгийн Газрыг (АТЗГ) долоон хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар нь Д.Чагдаржав, гишүүдэд Д.Бодоо, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, гүн Н.Билэгсайхан, бэйс Л.Сумьяа нарыг сонгож, үлдсэн нэг гишүүнийг Тагна-Урианхайн хязгаараас сонгохоор тогтжээ.

Хиагтыг чөлөөлсний дараа мөн сарын 24-нд НТХ, АТЗГ-ын хамтарсан хурлаар АТЗГ-т дотоод, сан, цэрэг гурван яамыг зохих хэлтсүүдтэй байгуулж, зохион байгуулалтын хувьд өргөтгөн бэхжүүлжээ.

Дотоод Яамны даргаар (сайд биш Д.У) гүн Н.Билэгсайханг томилж, Ерөнхий хэлтэс, гадаад хэргийн хэлтэс, харилцан нэвтрэлцэх хэлтэс, шүүх таслах хэлтэс, бүгд 8 оронтой байгуулжээ. Даргаар нь Д.Бодоо томилогдсон<sup>2</sup> Гадаад хэргийн хэлтэс нь бусад хэлтсүүдээс илүү чухалд тооцогдож байсан учир зарим албан бичигт "Гадаад Яам" хэмээн нэрлэсэн үзэгддэг. Чухамхүү энэ үеэс Монгол улсын дипломат алба сэргээн байгуулагдах эхлэл тавигдсан гэж үзэж болох юм.

Ардын журамт цэрэг Нийслэл Хүрээг тайван замаар чөлөөлсний дараа 1921 оны 7-р сарын 9-нд болсон НТХ-ны хурлаас Богдын Засгийн газрыг татан буулгах, засгийн эрхийг АТЗГ-ын мэдэлд шилжүүлэх түүхэн шийдвэр гаргаж, АТЗГ-ын зохион байгуулалтыг өргөтгөн гурван яам байсныг гадаад, дотоод, сан, цэрэг, шүүх таван яам болгож, яамдын удирдах тушаалтныг баталжээ. Үүнд:

1. Ардын Засгийн газрын ерөнхий сайдаар гадаад хэргийн хэлтсийн дарга Д.Бодоог, эрхэлсэн түшмэлээр бэйл Б.Цэрэндорж, нарийн бичгийн даргаар Э.Батхаан нарыг томилж, Яамдын сайд, дэд сайд нарыг Засгийн газрын гишүүн болгосон байна.

2. Гадаад Яамны тэргүүн сайдыг Ерөнхий сайдал хавсарган, дэд сайдаар гүн Жигмэддорж, эрхэлсэн түшмэлээр бэйл Б.Цэрэндоржийг мөнхүү хавсарган томилж, туслах, орчуулагч, бичээч зэрэг яамны орон тоог 28-аар тогтоожээ.<sup>3</sup> Дипломат албаны тэргүүнийг ерөнхий сайдал хавсаргасан нь гадаад харилцааны асуудал онцгой чухал байсны илрэл юм.

\* Д.Уламбаяр - ахлах багш

ГЯЯ-ны зохион байгуулалт үндсэндээ Богд Хаант засгийн үеийнхтэй адил, яамны удирдлагаас гадна гурван хэлтэстэй байв. Эдгээр нь Зөвлөлт Оростой харилцах асуудлыг хариуцах Умард, Хятад, Түвдийн хэрэг эрхэлдэг Өмнөд, хяналт, шалгалт, бичиг хэрэг, санхүү хариуцсан Ерөнхий хэлтэс юм. Яамны ажиллагсдын дотор бэйл Б.Цэрэндорж, бэйл А.Амар, гүн Жигмэддорж, бэйл Хатанбаатар, гүн Ж.Даваа, Г.Гүрсэд, А.Данзан, Ч.Амгалан зэрэг Богд Хаант Засгийн үед төрийн алба хашиж байсан бичгийн түшмэл, МАН-ыг талархан дэмжигч, эх оронч үзэлтэй хүмүүс байв.

Дээр дурдсан зөвлөлгөөн хэмжээт эрхт эзэнд өргөмжлөгдөх болсон Богд хааны шадар сайдаар Дотоод яамны тэргүүн сайд, да лам Пунцагдорж, ван Намсрай, ван Гүрсоронзонгомбосүрэн, ван Цогбадрах, Базарваань, гүн Дэндэв нарыг томилжээ.

1921 оны 7-р сарын 10-нд АТЗГ-ын шийдвэрлэсэн ёсоор хуучин Засгийн газрын Ерөнхий сайд хамаарсан Манширхутагт Цэрэндорж, шадар сайд да лам Пунцагдорж, Гадаад яамны тэргүүн сайд шанзав Дашзэвэг, Цэргийн яамны тэргүүн сайд ван Цогбадрах, Сангийн тэргүүн сайд гүн Цэвээн, Шүүх хэргийн тэргүүн сайдын тамга хамаарсан ван Жамьян, шадар сайд нар засаг төрийн хэрэг, тамга тэмдгийг шилжүүлэн өгчээ.

1921 оны 7-р сарын 11-нд Богд гэгээнийг хэмжээт эрхт хаанд өргөмжлөх ёслол үйлдэж, сүүлд улсын хаан болон засгийн газрын эрх мэдэл, харилцааны хэм хэмжээг боловсруулан мөрдөх шаардлага гарсны дагуу 1921 оны 11-р сарын 1-нд Ардын засгийн газрын (АЗГ) тогтоолоор “Тангарагын гэрээ” хэмээх дүрмийг баталжээ. Уг дүрэмд “Монгол улсын Богд Жавзундамба хутагт шарын шашны Богд эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй” гэж заагаад бүх чухал шийдвэр гаргах эрхийг АЗГ-т олгожээ. Ийнхүү гадаад бодлогын чиг шугамыг АЗГ, МАН-ын ТХ, түүний тэргүүлэгчид тодорхойлох болжээ.

1921 оны 7-р сарын 14-нд АЗГ-ын таван яам нийлж ард ангийн хэрэг үйлст үнэнч байхаа баталсан илэрхийлэлт гаргасан байна. Тангараг гэж хэлж болох илэрхийлэлтэнд өгүүлсэн нь: “Ардын эрхт засгийн газар байгуулж, сайд түшмэдийг сонгон томилж, засгийн хэргийг үүсгэн явуулав. Бид үнэнч шударгыг гол болгон зүтгэж, тус газар орон ба ард албатыг батлан хамгаалах, сайжруулан засах, шинэчлэн хувьсгах, хэвээр явуулах зэргийг олон бүхэн боловсортол зөвлөлдөн тогтоож дараа дараагаар шийтгэн явуулж, улсын үндсийг бататган, гадаад байдлаа бэхжүүлэн ард олныг сайжруулах хэрэгт санаа хүчнээ дуусган маш чин үнэнчээр чармайн зүтгэж, төвшин амгаланд хүргүүлсүгэй”<sup>4</sup> гэжээ.

1921 оны сүүлчээр ГЯЯ-ны орон тоог 35 болгож мөн Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог тус яамны бүрэлдэхүүнд оруулжээ. ГЯЯ улс хоорондын харилцааг эрхлэхээс гадна гадаадын харьяат иргэд,

пүүс компани болон гааль, мөн гадаадад гарсан монгол иргэдийг эрж сурвалжлах, тэднийг нутаг буцаах асуудлыг хариуцан ажиллах болов.

1924 оны Улсын анхдугаар Их хурал анхдугаар Үндсэн хуулийг баталж, БНМАУ-ын засаг төрийн байгууллага нь төрийн эрх барих дээд газар УИХ, түүний чөлөө цагт Улсын Бага хурал, тэдгээрийн чөлөө цагт Бага хурлын тэргүүлэгчид ба Ардын Засгийн газар болно гээд АЗГ нь Бүх Цэргийн ба Эдийн засгийн зөвлөл, Дотоод, Гадаад, Цэрэг, Санхүү, Шүүх, Ардыг гэгээрүүлэх, Аж үйлдвэр, Хянан байцаах яамдаас бүрэлдэхийг зааж, ГЯЯ-ны орон тоог нэмэж тус яамны сайдаар Улсын Бага хурлын гишүүн Санжийн Гиваабалжирийг баталжээ.

УИХ Монгол улсыг Бүрэн Эрхт Бүгд Найрамдах Ард Улс хэмээн тунхаглаж, гадаад улстай харилцахад улсаа төлөөлөх, гэрээ бичиг батлах, улсын хил хязгаарыг өөрчлөх, дайн зарлах, найрамдал байгуулах зэрэг чухал асуудлыг УИХ, түүний чөлөө цагт Улсын Бага хурлын гүйцэтгэх үүрэг болгон хуульчилсан байна.

Үндсэн хуульд: "...бидний Ардын Бүгд Найрамдах Улсаас гадаадтай харилцах засгийн бодлогыг бүх дэлхийн бага буурай улс ба жинхэнэ хувьсгалт ард түмний ашиг тус, үндсэн зорилготой нийцүүлэн явуулбал зохино" гэж заажээ. "Жинхэнэ хувьсгалт ард түмэн" гэсэн томъёолол нь манай гадаад бодлогыг пролетарийн интернационализмын зарчимтай нийцүүлэх гэсэн шугамын илрэл гэж үзэж болох юм.

Үндсэн Хуульд намын тухай заалт ороогүй боловч ялангуяа гадаад бодлогын асуудлыг шийдвэрлэхэд түүний оролцоо улам нэмэгдсээр байсан болно. Үүнийг тухайлбал УИХ-ын дараа удалгүй мөн оны 12 дугаар сард болсон ТХ-ны тэргүүлэгчдийн 49 дүгээр хурлын тогтоол нотолж байна. Тогтоолын 1 дүгээр зүйлд: "Тус улсын гадаад лугаа холбогдсон хэрэг маш чухал тул үүнээс хойш Засгийн газрын эрх барих гишүүд гадаад лугаа харилцах хэргийг эрхбиш урьдаар харьяат намын тэргүүлэгчдэд үзүүлэн зөвшөөрсний хойно сая гүйцэтгэвээс зохих учрыг уул гишүүдэд мэдэгдэн явуулах"<sup>5</sup> тухай заасан байна. Цаашилбал 1940 оны Улсын VIII Их хурлаас баталсан шинэ Үндсэн хуульд: "МАХН бол улс нийгмийн бүх байгууллагуудыг удирдах гол хүчин" хэмээн зааж намын удирдан чиглүүлэх үүргийг хуульчлан тогтоожээ. Энэ үеэс нам нь төрийн байгууллагуудаас дээгүүр эрх мэдэлтэй болж улсын гадаад, дотоод бодлогыг дангаар тодорхойлдог болжээ. Ингэснээр төр засгийн байгууллагуудын гадаад бодлогын чиг үүргийг ёс төдий болгосон юм.

1926-1930 оны хооронд ГЯЯ тус улсын дипломат ба консулын албаны үзэл баримтлал, зохион байгуулалт, чиг үүргийг бүрдүүлэх эхлэлийг тавьсан нэлээд ажил хийсэн байна. 1926 онд БНМАУ-аас ЗХУ-д суугаа Бүрэн эрхт төлөөлөгчийн газрын (1941 оноос 1950 он хүртэл Элчин яам гэж нэрлэж байсан) дүрэм, 1927 онд ГЯЯ-ны түр дүрэм, 1929 онд консулын

дүрмийг тус тус анх удаа боловсруулан төр засгийн удирдах байгууллагуудаар батлуулж мөрдөх болсон байна. Бүрэн эрхт төлөөлөгчийн газрын дүрэмд бүрэн эрхт төлөөлөгч болон бусад албан хаагчид, ажилчдын эрхлэх үүргийг заажээ. Төлөөлөгчийн газрын үндсэн үүргийг тодорхойлохдоо: “нэгэнт найрамдсан улстай найрамдлыг улам зузаатган бусад гадаад улсаас Москва хотноо суулгасан элчин сайд, төлөөлөгчидтэй учиран танилцаж, тэдний дотроос найрамдваас зохих улстай найрамдлын холбоо байгуулж өөрийн улсад тустай хэрэг бүтээхийг ямагт хичээн оролдож аль аль улстай хэрхэн харилцан нэвтрэлцсэн... зэрэг байдал төлвийг урьд олгосон заавар ёсоор тодорхойлон тухай бүр Засгийн газар ба ГЯЯ-нд уламжлан явуулж гүйцэтгэвээс зохимой”<sup>6</sup> гэжээ.

ГЯЯ-ны түр дүрэмд яам, түүний хэлтсүүд болон албан хаагчдын гүйцэтгэх үүрэг, тайлан тооцоо гаргах ба хяналт шалгалт явуулах журмыг тус тус заажээ. Түр дүрэмд Өрнөд хэлтэс нь Европ, Африк, Австрали тивийн улсууд, Дорнод хэлтэс нь Дундад улс, Түвд, Тагна, Дива (Герман), Япон, АНУ-тай холбогдсон хэргийг эрхлэх тухай дурдаад эдгээр хэлтэс нь “өөрөөр хариуцвал зохих улсын дотроос найрамдсан улсад тус улсаас суулгах элчин сайдууд ба харьяат албан хаагчдын орон тоо, цалин хэрэглэлийг батлан тогтоолгох, мөнхүү элчин сайдуудад заавар дүрэм олгох” ажлыг хариуцан гүйцэтгэх тухай заасан байна.<sup>7</sup>

Улсын анхдугаар Их хуралд ГЯЯ-ны сайдаас оруулсан илтгэлд 1924 оны 11 дүгээр сарын 12-нд гаргасан тогтоолын 9 дүгээр зүйлд “...Гадаад улс оронд одогчдод түүний төрсөн газар, нас, төрөл садан, аж явдал зэргийг тодорхойлсон паспорт гэдэг үнэмлэх бичгийг шийтгэн олгуулж оруулбал зохино”<sup>8</sup> гэж тогтоожээ. Энэ саналыг 1925 оны 4 дүгээр сарын 3-нд Засгийн газрын 11 дүгээр хурлаар хэлэлцээд “...Энэхүү паспорт бичгийг олгуулах нь зүйтэй болох тул эл бичгийг дэвтэр болгон үйлдүүлбээс зохино”<sup>9</sup> гэжээ. Ийнхүү Монгол улсын гадаад паспорт бий болсон бөгөөд түүнийг цаашид боловсронгуй болгох талаар 1926 онд Засгийн газрын хурал, Улсын III их хурал, 1927 оны Улсын IY их хурал тус тус хэлэлцсэн байна.

Мөн Анхдугаар Их хурлын төлөөлөгчид Англи зэрэг гадаадын харьяат нар зөвшөөрөлгүйгээр далбаа хийсгэх нь зохихгүй, баргууд дураар ирж газар нутаг эзэмшиж гажуудуулж байгаа учир дагаар орохоос бусдыг оруулахгүй байх, Америк, Англи зэрэг шунахайчид арга мэх хэрэглэн ашиг олж байгааг зогсоох, түвдүүд шавар бурхан зэрэг хуурамч зүйлийг өгч Монголчуудыг мөлжиж байна. Иймээс гаалийг чангатгах, Хятад бол Монголын ард түмнийг хэтэрхий мөлжиж байгаа тул мөлжлөгийг устгах, Англи, Америкийн далбаа хэрэглэж мал худалдан авч явдаг буриадууд байна. Эдгээр асуудлыг энэ хурлаар шийдвэрлэх хэрэгтэй гэсэн шаардлага тавьж байжээ.

1926 оноос гадаадад суралцаж эхэлсэн оюутны асуудлыг ГЯЯ хариуцах болов. Монголд байгаа гадаадын иргэдийн байдал Монголын төр, засгийн анхаарлын төвд ямагт байсаар ирэв. Гадаадын харъяат нарт хамгаалах бичиг олгох тухай дүрмийг АЗГ 1921 онд батлан гаргажээ. Эл асуудлыг ГЯЯ хариуцаж байсан учир ийм баримт бичиг олгох нь юуны өмнө аль улсын иргэн болох, ямар ажил хөдөлмөр эрхлэн амьдран суугааг тодруулан тогтооход чухал байв. Хамгаалах тэмдэгт бичиг нь гадаадын иргэдийн Монголд оршин суух үнэмлэх юм.

Хилээр нэвтрэх гадаадын олон хүмүүсийн шударга, самууныг хянан сэргийлэх тухай дүрэм (1923 он), тус улсад суугаа Хятад иргэдийг цөөлөх ба нэмэн ирүүлэхийг хэмжээлэх тухай дүрмийг (1924 он) Засгийн газар тус тус батлан гаргажээ. Эдгээр нь өнөөдөр ч сургамжтай. Гадаадын харъяат хүмүүсийг тус улсад дагаар оруулан харъяат болгох дүрмийг ч мөн Засгийн газар батлан гаргажээ.

“БНМАУ-ын Консулын дүрэм”-ийг 1929 оны 1 дүгээр сарын 29-нд Улсын Бага хурал батлав. Энэ дүрэм Монгол улсын консулын албаны эрх зүйн гол тулгуур баримт бичиг болж байв. 7 бүлэг, 67 зүйлтэй энэ дүрмээр консулын байгууллагын эрх үүрэг, зохион байгуулалт бүтэц, консулын газар байгуулах, консулын ажилтны үүрэг, зэрэг дэвийг тодорхойлжээ. Түүнийг боловсруулахдаа олон улсын практик, Монгол улсын ГЯЯ-ны консулын салбар дахь үйл ажиллагааны тухайн үеийн онцлог байдлыг харгалзан тусгажээ. Консулын дүрмийг баталсны дараа 1929 оны 2 дугаар сарын 15-нд Засгийн газар ЗХУ-ын Троицкосавскт Монголын консулыг суулгах шийдвэр гарч Консулын газрын бүрэлдхүүн, төсвийг баталжээ.<sup>11</sup> Энэ бол Монгол улсаас ЗХУ-д суулгасан анхны бие даасан консулын газар байв. Түүнчлэн ГЯЯ өөрийн төлөөний түшмэлүүдийг 1927 оноос эхлэн хөдөө аймгуудад (Баянтүмэн, Жавхлант, Жаргалант зэрэг төвд) томилон суулгах болсон байна. Эдгээр төлөөний түшмэд нь эрх зүйн хувьд ГЯЯ-ны эрхэлсэн түшмэлийн зиндаанд байжээ. Төлөөлөгчийн үүрэг нь тус улсаас бусад улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг аймгийн байгууллагууд хэрхэн биелүүлж байгааг хянах, гадаадын консулын газрууд болон гадаадын иргэлтэй орон нутгийн байгууллагаас харилцахад туслах, гадаадын консулын газартай ГЯЯ-ны нэрийн өмнөөс харьцах, албан ажлаар гадаадад явах хүмүүст дипломат, албан паспортад виз олгох үүрэгтэй бөгөөд төлөөлөгчдөд ГЯЯ-ны сайдын гарын үсэгтэй үнэмлэх олгохоор тогтоосон байна. 1932 оны 9 дүгээр сарын 25-нд батлагдсан ГЯЯ-ны дүрмийн дагуу аривлан хэмнэх зорилгоор орон тооны төлөөний түшмэлийг хасаж тэдний гүйцэтгэж байсан үүргийг орон нутгийн захиргааны дарга нарт хавсаргасан байна.

Түүнчлэн Монгол улсын гадаад харилцаа, дипломат албаны түүхэнд дурьдагддаггүй асуудал бол 1921 оны 7-р сарын 24-нд Ардын засгийн

газрын удирдлаган дор Ховдод байгуулагдсан Баруун Монголын засгийн газар юм. Энэ тухай С.Ш.Нацов,<sup>12</sup> Г.Кунгуров, И.Сороковиков,<sup>13</sup> Роберт А.Рупен,<sup>14</sup> Ц.Дамбадорж<sup>15</sup> нар өөрсдийн бүтээлүүддээ тэмдэглэж байжээ. Эх сурвалжид Баруун Монголын Хязгаарын Засгийн газар, Ховдын хязгаарын өөртөө засах Засгийн газар гэх мэтээр тэмдэглэжээ. Засгийн газрын тэргүүнд Далай Дөрвөд хан Түмэн Дэлгэржав, тэргүүн дэдэд Үнэн Зоригт хан Содномжамц, ГХЯ-ны тэргүүн сайдал гүн Цэвээн, дэд сайдал Коминтерний төлөөлөгч, буриад С.Ш.Нацов, Дотоод яамны сайдал Түмэн Бадам гүн Аюурзана, дэд сайдал намын суртал номлогч Ц.Дамбадорж, Ерөнхий командлагч бөгөөд Цэргийн яамны сайдал Хасбаатар, дэд сайдал ван Самдан нар Хүрэннээс томилогдон ажиллаж байв. Баруун Монголын засгийн газрын ГХЯ-ны гол зорилго нь нутгийн баруун хязгаарт бүгсэн Бакич, Кайгородов, Казанцеваар удирдуулсан Барон Унгерний үлдэгдэл цагаантны томоохон хүчнийг бут цохиход Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын ГХЯ, Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын Монгол-Түвдийн хэлтэс, улаан армийн анги, нэгтгэлүүдтэй гадаад харилцааны асуудлыг газар дээр нь шуурхай зохицуулах явдал байжээ. Улс орноо цагаантны үлдэгдлээс бүрмөсөн цэвэрлэсний дараа 1922 оны 7-р сард Баруун Монголын хязгаарын засгийн газрыг татан буулгасан байна.

## II. Монгол-Зөвлөлтийн найрамдлын анхны гэрээ бичиг, Монгол улсыг хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн үндэслэл

Шинэ тутам тогтсон Ардын эрхт төрийн гадаад бодлого, дипломат ажиллагааны үндсэн зорилт нь аанай л тусгаар тогтнолоо хөрш болон бусад олон улсаар хүлээн зөвшөөрүүлэх явдал байлаа. Ардын эрхт Засгийн газар шинээр буй болсон хойд хөршид ихээхэн найдвар тавьж байсан учир нь 1919 онд Зөвлөлийн засагт Оросын улсын Ардын комиссариатаас автономит Монголын Засгийн газарт мэдтүгэй хэмээн тусгайлан илгээсэн ноот бичиг мөн байлаа. Түүнд “Оросын ард түмэн Монголын тухай Япон, Дундад хоёр улс лугаа урьд хааны үед байгуулсан аливаа гэрээ зүйлийг цөм устгасны учраас үүнээс хойш Монгол улс болбоос өөртөө эрхт тусгаар нэгэн орон мөн тул Монголын дотоод хэрэгт ямар ч гаднын хүн нар оролцох эрхгүй, мөнөөхөн 1913 оны гэрээ бичгийг зогсоож Монгол Улс тусгаар тогтносон орны ёсоор Бээжин, Петерград хоёроос асуулгүй аливаа олон улс лугаа шууд харилцан нэвтрэлцэх эрхтэй болсон явдлыг манай Зөвлөлт Засгийн газраас Монгол үндэсний улсад чухам мэдэгдэн тунхаглахын хамт манай Орос улс лугаа даруй харилцан нэвтрэлцэж элчин явуулан, эрх чөлөөт Монголын төлөөний хүмүүсийг манай Улаан цэргийн өмнөөс тосон илгээх ажаамуу”<sup>16</sup> гэж мэдэгджээ.

Монгол орны дотоод болон гадаад орчны өөрчлөгдөж буй нөхцөл байдалтай уялдан ЗОУ болон Монголын хувьсгалын удирдагчдын байр суурь, үзэл бодол, хувьсал өөрчлөлтийг дамжиж ирсэн нь тодорхой билээ. Ер нь 20-иад оны эхэн бол тус орны улс төр, эдийн засаг оюуны амьдралд эргэлтийн шинжтэй гэж хэлж болохуйц, ингэхлээрээ нарийн түвэгтэй, үүгээрээ манай шинэхэн түүхийн нэн сонирхолтой үе гэж хэлж болохоор юм. Учир нь урьд өмнө шийдвэрлэж байгаагүй олон чухал асуудлууд энэ үед цоо шинээр дэвшигдэн гарч иржээ. Улс төрийн зүтгэлтнүүд, олон түмэн тэдгээр үзэгдэл, үйл явцийг өөр өөрийнхөөрөө үнэлж цэгнэж, янз бүрээр хандаж байв. Хувьсгалын удирдагчид үйл явдлын хурц үзүүр дээр байж, улс төрийн зоримог шийдвэр гаргаж өнөө болон ирээдүйн төлөө бүхий л хариуцлагыг өөртөө хүлээх өндөр үүрэгтэйг ухамсарлан ойлгож байв. Янз бүрийн үзэл бодол, эрх ашиг хутгалдсан нарийн түвэгтэй нөхцөлд тууштай хувьсгалчдын нам гол зорилгыг олж, олон янз хандлага, эрмэлзлийг нэгтгэн тэдгээрийг хувьсгалын үндсэн асуудалд чиглүүлэхийг чармайсан юм.

1921 оны 2 дугаар сарын 10-нд Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар “Унгерн Монголыг эзэлснээр Коминтерн ба ЗОУ хувьсгалт баазаа алдах аюул буй болов... Приморийн мужаас Семёнов, Манжуураас Жан Золин, Монголоос барон Унгерний хүрээлэл бүхий хар халхавчийг Япон бий болгож байна... Энэ халхавчийг наад зах нь түүний Монгол дахь шижмийг эвдэхэд Коминтерн ба ЗОУ-ын дайчин зорилт оршино”<sup>17</sup> гэсэн тогтоол гаргав. Зөвлөлт Засгийн газар Монголд явуулах ажилд зориулан Монгол-Түвдийн хэлтсийн мэдэлд 150 кг мөнгө, 100000 доллар, зэвсэг, хувцас хэрэгслэлийг шилжүүлжээ. 1920 оны 8 дугаар сард С.Данзан тэргүүтэй хувьсгалчдын анхны долоон гишүүн Эрхүү, Москвад, Г.В.Чичерин, Я.Д.Янсон, Ф.Н.Гапон, С.С.Борисов нартай уулзсан нь цаашдаа чухал учир холбогдолтой байв.

1921 оны 3 дугаар сарын МАН-ын анхдугаар их хурлын тэмдэглэл бичигт: “Монголын ард түмний хүсэл эрмэлзлийг Зөвлөлийн засагт их Орос улсын гадаад бодлого дэмжиж буй нь бодитой тул бид ирээдүйн их хэргийг Зөвлөлт Оросын найрамдлыг түшиглэн бүтээх ёстой”<sup>18</sup> хэмээн дурдсан байна. Улмаар 1921 оны 3 дугаар сарын 20-нд Монгол Ардын Засгийн хэргийг Бүгд түр захиран шийтгэх газраас Засгийн газрын дарга Д.Чагдаржав, гадаад хэргийг эрхлэн шийтгэх түшмэл Д.Бодоо нарын гарын үсэгтэйгээр “Их Орос улсын Зөвлөлт засгийн газар Алс Дорно дахь Бүгд Найрамдах Засгийн газраа мэдтүгэй” хэмээн илгээсэн бичгийн дотор “Манай Монголын олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны хоёр сарын шинийн гуравны өдөр манай тусгаар тогтносон Монголын Ардын засгийн хэргийг Бүгд түр захиран шийтгэх газар байгуулсан явдлыг мэдэгдэж, Эрхэм улсын засгийн газраас тусгай төлөөний элч гаргаж манай засгийн газар лугаа хэрэг зориг шийтгэхэд

дав дув болгох ажаамуу” хэмээн өгүүлжээ. Энэхүү бичиг бол Монгол Ард Улсаас гадаад улс оронтой тусгаар тогтносон улсын байр сууринаас харилцахыг эрмэлзэж илгээсэн хамгийн анхны баримт бичиг мөн.

1921 оны 9 дүгээр сарын 10-нд Монголын Ардын Засгийн Газраас ЗОУ-ын ГХАК-д илгээсэн бичигтээ: “...хил хязгаар нийлсэн айл улсууд харилцан тусалж, найрамдлыг зузаатгах явдлыг эрхэмд бодсоноо илэрхийлэн... Монгол улсын гадаад олон улстай эв найрамдал ба худалдааны гэрээ байгуулан, энгийн бат барилдлагыг илрүүлэн ёсоор явуулах хэрэгт хөндлөн этгээд болон зуучлан оролцож, тусламж үзүүлнэ үү...”<sup>19</sup> хэмээн хүсчээ.

Дурдсан бичгүүдийн хариуг ЗСБНХОУ-ын ГХА-ын комиссар Г.В.Чичериний нэрээр 9 дүгээр сарын 21-ний өдөр шийтгэн ирүүлснийг сийрүүлбээс “Оросын засгийн газар, танай хувьсгалт Ардын Засгийн газраас манай олон түмэн ба Зөвлөлийн Засгийн газарт найрамдлыг илтгэн, эрхэм таны бичигт итгэмжийг батлан ирснийг мэдэж ихэд баясав. Оросын Засгийн газраас Монголын хувьсгалт Засгийн газрын Хятадтай найрамдал аливаа хэргийн учир харилцан нэвтрэлцэхтэй хамт тус улсын язгуурын чөлөө эрхийг батлах гэснийг машинд зөвшөөрөөд энэхүү хэргийг дав дуваар бүрэн бүтэн болгохыг итгэмжлэн...”<sup>20</sup> гэжээ.

Үүний өмнөхөн 1921 оны 6 дугаар сарын сүүлээр Москвад хуралдсан Коминтернийн III хуралд Ж.Цэвээн (С.Бегзеев), Хоролхүнд тэргүүтэй АТЗГ, МАН-ын төлөөлөгчид оролцжээ. АТЗГ төлөөлөгчдөд ЗОУ-ын ГХАК-тай хоёр орны харилцааны талаарх аливаа асуудлаар хэлэлцээ хийх бүрэн эрхийн үнэмлэх шийтгэн олгосон бөгөөд түүний дагуу Г.В.Чичерин зэрэг нөхөдтэй Ардын хувьсгалын ялалтын дараа хоёр орны харилцааг өргөтгөн бэхжүүлэх, урианхайн хязгаар, цагаантны үлдэгдлийг бут цохих зэрэг асуудлаар 3 цаг гаруй үргэлжилсэн уулзалт яриа хийжээ.<sup>21</sup> Энэ нь хоёр орны найрамдлын анхны хэлэлцээрийн чухал бэлтгэл болсон юм.

Зөвлөлт Засгийн газартай урьдчилан хэлэлцэж тохиролцсон ёсоор Монгол, Зөвлөлтийн Засгийн газрын хооронд хэлэлцээр хийх бүрэн эрхт төлөөлөгчдийг МАН-ын ТХ, АЗГ 1921 оны 9 дүгээр сарын 27-нд томилжээ. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд МАН-ын ТХ-ны дарга, Сангийн Яамны сайд С.Данзан (төлөөлөгчдийн тэргүүн), Цэргийн Яамны сайд Д.Сүхбаатар, Гадаад Яамны дэд сайд Б.Цэрэндорж, Богд гэгээний биет төлөөлөгч Эрдэнэ жонон ван Ц.Ширнэндамдин, нарийн бичгийн даргаар гүн Б.Даваа, орчуулагчаар Эрдэнэбатхаан нар томилогджээ.<sup>22</sup> Монголын бүрэн эрхт төлөөлөгчдийн бүрэлдэхүүний тухай Б.З.Шумяцкий В.И Ленинд танилцуулсныг сийрүүлбэл:

“1. Данзан - Сангийн яамны сайд бөгөөд Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны дарга. Монголын Ардын Хувьсгалт Намын идэвхтэй



гишүүний нэг. Оросоор бага зэрэг ярьдаг. Харц ардаас гаралтай. Урьд автономит Монголын засгийн газарт ойн цагдаа хийж байсан. Ардын хувьсгалт хөдөлгөөнд тусламж эрэхээр 1920 онд Ардын хувьсгалт намын төлөөлөгчидтэй хамт Москвад ирж байсан.

2. Жонон ван Ширнэндамдин - Төлөөлөгчдийн албан ёсны бус гишүүн. Богд гэгээний бие төлөөлөгч болж ирсэн... Хятадын талыг баримтлагч, ер бусын баян. Хар, шар феодалуудын дотор нөлөө ихтэй, нэлээд соёлтой хүн. Нийслэл хүрээнд европ маягаар амьдран суудаг. Хөдөө аж ахуйг боловсноор эрхлэхийг хүсэж байдаг. Орос-Хятад-Монголын хуучин бараг бүх хэлэлцээрүүдэд оролцож явсан. Цагаан хааны ордонд ирж байсан.

3. Сүхбаатар - Монголын ардын хувьсгалт цэргийн жанжин, Цэргийн яамны сайд. Харц ард, Монгол оронд үүсэн бүрэлдэж буй шинэ харилцаануудын биет төлөөлөгч мөн. 29 настай залуу хүн боловч гойд эрэлхэг зоригтой. Түүний тухай ард олны дунд баатар эрийн ёсоор нэгэнт домоглон хэлэлцэх болжээ. Ардын Хувьсгалт Намын идэвхтэн зүтгэлтний нэг. Монголын шилдэг уран илтгэгч. Цэргийн эрдэмд дуртай бөгөөд түүнд өөрөө сурч, бусдыг сургадаг. Зөвлөлт Орос улсын талыг баттай баримталж байна. Оросоор бага зэрэг ярьдаг.

4. Цэрэндорж - Гадаад явдлын яамны дэд сайд. Хуучин монголын харц ардаас дан ганц өөрийн эрдэм чадлаараа Гадаад явдлын яамны сайд болтлоо дэвшсэн ахмад түшмэл. Орчуулгын ёс, парламентризмын тухай зохиол бичсэн. Роман бичигч, яруу найрагч, хятадын утга зохиолыг монгол хэлнээ хөрвүүлдэг шилдэг орчуулагч. Зөвхөн монгол, хятад хэл мэднэ. Түүний оролцоогүйгээр нэг ч хуулийн төсөл, нэг ч дипломат баримт бичиг гарч байгаагүй. Богд гэгээн энэхүү соёлт харц ардад тун дургүй, түүнд хор өгөхийг оролдож байсан удаа ч бий. Цэрэндорж Зөвлөлт Орос улсын талыг баттай баримталж байна.

5. Батхаан - Төлөөлөгчдийн зөвлөгч бөгөөд хариуцлагатай орчуулагч. Оросын буриад, дунд боловсролтой сурган хүмүүжүүлэгч хүн. Унгернд хяхагдан хавчигдаж байсан бөгөөд одоо манайханд бахдам сэтгэлээр хандаж явдаг хүн<sup>23</sup> гэжээ.

Зөвлөлтийн талаас төлөөлөгчдийн тэргүүнээр ЗСБНХОУ-ын ГХАК-ын Алс Дорнодын хэлтсийн эрхлэгч С.И.Духовский, гишүүдэд эдийн засаг, эрхийн төлөөлөгч Б.Ф.Гец, нарийн бичгийн даргаар улс төрийн асуудал эрхэлсэн референт Л.Е.Берлин, орчуулагчаар Н.Очиров нар оржээ. Харилцан адилгүй төвшиний бүрэлдэхүүнтэй хоёр талын хэлэлцээр 1921 оны 10 дугаар сарын 26-нд Москва хотын “Метрополь” зочид буудалд эхэлж, Монголын талын санал болгосон гэрээний 12 зүйл бүхий төслийг үндэс болгон хэлэлцэж, нийтдээ 5 удаа хуралдаж “Монгол, Орос хоёрын хоорондох Найрамдлын барилдлага байгуулах тухай гэрээ” бичигт 1921 оны 11 дүгээр сарын 5-нд гарын

үсэг зуржээ. Гэрээ бичгийн оршилд “Урьдын Оросын хаант засгийн газраас түүний зальт шунахай бодлогын хүчээр дарлаж автономит Монголын засгийн газартай байгуулсан гэрээ бичгүүд хоёр улсад шинэ байдал тогтсон учир хүчингүй болсон” ба хоёр айл улсын харилцан туслалцах чөлөө найрамдлыг хүссэнийг онцлон тэмдэглэжээ. Гэрээ бичгийн нэгдүгээр зүйлд “Зөвлөлийн Засагт Орос улсын Засгийн газраас гагцхүү хуулийн ёсоор эрх барьсан Монголын Ардын Засгийн газрыг хүлээн зөвшөөрөв”. Тавдугаар зүйлд “Монгол Ардын Засгийн газраас Зөвлөлийн засагт Орос улсын Нийслэлд бүрэн эрх барих төлөөний элчин суулгаж болно. Бас Зөвлөлийн засагт Орос улсын Засгийн газартай зөвлөн хэлэлцэж хилийн ойрхи мужуудад консул суулгаж болно”<sup>24</sup> гэжээ. Гэрээний хоёр, дөрөвдүгээр зүйлд мөнхүү тийм эрхийг Монгол Ардын Засгийн газар хүлээн зөвшөөрсөн юм.

Гэрээ бичигт хэдийгээр хоёр улс бие биеийнхээ тусгаар тогтнолыг харилцан зөвшөөрсөн тухай заагаагүй боловч бүрэн эрхт дипломат төлөөлөгч солилцохоор тохиролцож харилцан суулгасан нь хоёр улс олон улсын эрх зүй ёсоор хэрэг дээрээ *de jure* зөвшөөрсөн гэж үзэх үндэстэй юм хэмээн академич Б.Лхамсүрэн, дипломатч М.Дүгэрсүрэн нар өөрсдийн бүтээлүүддээ тэмдэглэсэн байна. Харин судлаач, доктор Ж.Бор “гэрээг Монголын талаас Ерөнхий сайдын орлогч бөгөөд Сангийн сайд, МАН-ын ТХ-ны дарга С.Данзан мутарласан байхад Зөвлөлтийн талаас ГХАК-тын газрын хэлтсийн эрхлэгч С.Духовский мутарласнаас үзэхэд ЗОУ өөр дээрээ хүлээж авсан үүрэг нь тун бага юм. Нөгөөтэйгүүр Засгийн газрыг хүлээн зөвшөөрсөн нь тусгаар тогтносон болоод өөртөө эзэрхэг (автономит) эрхтэй улсын Засгийн газрын аль нь ч байж болохоор байв. Өөрөөр хэлбэл Монголын тусгаар тогтнолыг *de jure* хүлээн зөвшөөрөх асуудал тавигдаагүй юм. Түүнчлэн гэрээ бичгээр олон улсын эрх зүйн үүднээс зарчмын гэж хэлэгдэхээр үүрэг хүлээж аваагүй, тусгаар тогтнолын асуудлыг гурав дахь буюу Хятадтай харилцаа хэрхэн бүрдэхээс хамаарахуйцаар нээлттэй орхисон учраас *de facto* ч хүлээн зөвшөөрсөн гэж үзэхийн аргагүй юм... 1921 онд гэрээ байгуулснаар үндэснийхээ эрх чөлөөний төлөө босож тэмцсэн талыг хүлээн зөвшөөрсөн үе шувтарч хоёр улсын харилцааны хоёр дахь үе эхэлсэн юм. Энэ үе нь 1921 оны сүүлээс 1945 он хүртэл үргэлжилсэн бөлгөө” гэж асуудлыг эсрэгээр тавьжээ.

Олон улсын эрх зүйд (ОУЭЗ) шинээр буй болсон субъекттэй бусад улс эрх зүйн харилцаанд ороход бэлэн байгаагаа илэрхийлэхийг хүлээн зөвшөөрөх гэдэг билээ. Аливаа улс өөр улс болон засгийн газрыг хүлээн зөвшөөрөөд түүнтэй дипломат харилцаа тогтоохгүй байж болно. Харин дипломат харилцаа тогтоосон атлаа хүлээн зөвшөөрөөгүй байж үл болох билээ. Өөрөөр хэлбэл дипломат харилцаа тогтоох нь хүлээн

зөвшөөрсний нотолгоо болдог. Олон улсын талаас хүлээн зөвшөөрөх гол объект бол шинэ улс ба засгийн газар юм. Үүнээс гадна үндэстэн, ард түмэн, эсэргүүцлийн хөдөлгөөн, байгууллага, дайтагч ба босогч талууд хүлээн зөвшөөрөх объект болж байдаг.

Хувьсгалын үр дүнд төр нийгмийн байгуулалт үндсээрээ өөрчлөгдөх үед мөн хүлээн зөвшөөрөх асуудал гарч болох бөгөөд ийм нөхцөлд ялангуяа улс гүрний нутаг дэвсгэрт онцын өөрчлөлт ороогүй бол голдуу шинэ засгийн газрыг хүлээн зөвшөөрдөг практик буй болсон билээ. Хүлээн зөвшөөрснөөр тухайн улсад гарсан төрийн өөрчлөлтийг сайшаасан хэрэг биш юм. Харин шинэ засгийн газрыг хүлээн зөвшөөрсөн улс, хуучин засгийн газар нь тухайн улсыг төлөөлөхөө болж, түүнийг олон улсын харилцаанд төлөөлдөг цорын ганц байгууллага бол шинэ засгийн газар хэмээн зөвшөөрсний илэрхийлэл мөн.

Дэлхийн II дайны өмнөх ОУЭЗ-д улс ба засгийн газрыг хүлээн зөвшөөрөхөөс гадна босогч ба дайтагч тал, мөн үндэстэн, ард түмнийг хүлээн зөвшөөрдөг практик буй болжээ. Үйл ажиллагаагаа хариуцах чадвар бүхий улс төрийн байгууллагын удирдлагаар дайны ажиллагаа явуулж байгаа этгээдийг дайтагч тал, тийм байгууллага үгүй бол босогч тал гэж ОУЭЗ-д үзэх болжээ. Хүлээн зөвшөөрөгдсөн дайтагч ба босогч талд дайны үеийн эрх зүйн хэм хэмжээ учир холбогдолтой болж, тэдгээрийг хууль ёсны засаг төрийн эсрэг тэмцэгч гэмт хэрэгтэн биш хэмээн үзэх болсон байна. Босогч ба дайтагч тал нь хүлээн зөвшөөрсөн ОУЭЗ-н субъекттэй харилцаа тогтоож тусламж, дэмжлэг авах боломжтой болов. Үүнд тэдгээрийг хүлээн зөвшөөрсний хууль эрхийн гол үр дагавар оршино. Өөртөө засан тохинох зарчим бий болсноор үндэстэн, ард түмнийг хүлээн зөвшөөрөх явдал хууль эрхийн бат үндэстэй болсон билээ. Бүрэн хэмжээгээр албан ёсоор хүлээн зөвшөөрөхийг *de jure* хүлээн зөвшөөрөх гэх ба хүлээн зөвшөөрөхийн олон улсын практикийн сонгодог хэлбэр юм. Бүрэн төгс биш хүлээн зөвшөөрөхийг *de facto* хэмээх ажээ. Энэ нь тухайн улс буюу Засгийн газрын баттай оршин тогтнох чадварт эргэлзэж байгаагийн илрэл бас болдог. Нөгөө талаар *de jure* хүлээн зөвшөөрөхийн бэлтгэл алхам болох явдал ч практикт тогтжээ. *De facto* хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хоёр улсын хооронд зөвхөн консулын болон худалдаа, эдийн засгийн харилцаа тогтох агаад бүрэн дипломат статусгүй төлөөлөгчдийг солилцдог. 1922-1950 он хүртэл Москва дахь Монгол улсын элчин сайдыг “бүрэн эрхт төлөөлөгч” буюу (полпред), “бүрэн эрхт элчин төлөөлөгч” буюу (посланник), ЭСЯ-ыг “бүрэн эрхт төлөөлөгчийн газар” буюу (полномочный представительство), “элчин төлөөлөгчийн газар” буюу (Миссия) хэмээн нэрлэж байсан юм.

Монголын төлөөлөгчид “Монгол, Орос хоёрын хоорондох Найрамдлын барилдлагаг байгуулах тухай гэрээ” бичгээр өөрийн улсын

тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлсэн гэж үзэж байсан билээ. Хэлэлцээрийн төгсгөлд С.Данзан үг хэлэхдээ: “Манай монголчууд дав дээр арга үгүй Хятадад захирагдаж байхуй дор Зөвлөлийн Засагт их Орос улсын Засгийн газраас Дорно зүгийн олон улсад тусгайлан зарласан бичгийг үзвээс эзэрхэг хааны үед 1912 оноос эхлэн удаа дараа тогтоосон Орос-Монголын гэрээ бичгүүдийг бүрмөсөн устгаж, эдүгээ Зөвлөлийн Засагт их Орос улсын Засгийн газраас урьд эзэрхэг императорын засгийн газартай адил бусад улсын засгийн газарт хэтэрхий шунахайрахгүй хэмээн зарласныг үзэж айл их Орос улсын санаа сайхан, түмэнд тустай хүслийг баярлан мэдээд ЗОУ-аас тусламж гуйсанд манай Монгол мэт бага буурай улсыг бусад их улсуудын эрх мэдэлд байвал зохино хэмээх үгүй, харин манай төлөөгч нарыг сайнаар хандан хүлээж нөхрийн тусламж үзүүлсэн нь мөн эдүгээ Зөвлөлийн Засагт их Орос улсын тусламжаар Монголын ард түмэнд эрх чөлөө олгосон болой. Манай Монголд их тусламж үзүүлсэн их улсад Монголын ард ба АЗГ-ын өмнөөс их баяр хүргэе. Энэ өдөр гарын үсэг зурж, гэрээ бичиг тогтоож, хоёр улсын хооронд бүхүй найрамдлыг илрүүлэн, үүрд найрамдал тасрахгүй харилцан туслахын сайн билэг тодорвой”<sup>25</sup> гэж хэлснээс тодорхой байна. Энэ хэлэлцээрийн хэлэлцэх асуудал тодорхой байсан учраас Хиагтын гурван этгээдийн хэлэлцээр лугаа урт удаан олон хоног сунжраагүй юм.

Харин ЗОУ-ын бодлогын цаад санаа нь тэс өмнөө байжээ. Найрамдлын Гэрээ байгуулахаас өмнөхөн Б.З.Шумяцкий Г.В.Чичеринд илгээсэн бичигтээ: “Бид Монголын олон түмнээр төлөөлүүлэн, үндэснийхээ нэгдлийн болон зарим талаар оршин тогтнох хувь заяагаа Зөвлөлт Орос улстай холбосон тодорхой найз нөхөлтэй болов. Бид манай олон мянган километр хил хязгаарын хамгийн эмзэг газрыг халхалсан холбоотныг өөртөө бий болгов”<sup>26</sup> хэмээжээ.

ЗОУ 1921 оны найрамдлын гэрээгээр Монгол улсыг de facto хүлээн зөвшөөрсөн нь Монгол улс олон улсын харилцаанд эрх эдэлж, үүрэг хүлээх чадвар бүхий олон улсын эрх зүйн шинэ субъект мөн болохыг нотлон харуулж, энэ нь Хятад, Японы эзэрхэг бүлгийнхэнд цохилт болж, Өрнөдийн орнуудын анхаарлыг татсан юм. ЗОУ-ын ГХА-ын комиссар Г.В.Чичерин 1921 оны 11 дүгээр сарын 6-ны “Известия” сонинд Октябрийн хувьсгалын 4 жилийн ойд зориулж “Зөвлөлт засгийн Дорнодын бодлогын нэг жил” хэмээх нэртэй томоохон өгүүллийг нийтлүүлжээ. Түүнд Зөвлөлт Засгийн газраас Турк, Иран, Афганистан, Хятадтай тогтоосон шинэ харилцааны тухай тэмдэглэхийн хамт Монгол Ардын Хувьсгалт Засгийн газартай Монгол, Оросын хооронд ах дүүгийн найрамдлын барилдлагын тухай гэрээ байгуулсаны ач холбогдлыг өндөр үнэлсэн байна.<sup>27</sup>

1922 онд 10 дугаар сард ЗСБНХУ байгуулагдсан учрыг Зөвлөлт Засгийн газар Монголын Засгийн газарт мэдэгдэхдээ 1921 онд ЗОУ-тай

байгуулсан найрамдлын гэрээ бүрнээ хүчин төгөлдөр хэвээр байх болно, тэрхүү гэрээний үндсэн дээр хоёр орны хоорондын найрсаг харилцаа, нөхөрсөг хамтын ажиллагааг бүх талаар улам бүр өргөжүүлэн хөгжүүлэхийг хүсэж байгаагаа албан ёсоор мэдэгдсэн байна.<sup>28</sup>

1921 оны 12 дугаар сарын 31-нд найрамдлын гэрээг Улсын Түр Цагийн Хурлын 8 дугаар хуралдаан сонсож сайшаасан бол 1924 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын анхдугаар Их хурал батламжилж, "...манай Монгол улсад үнэн сэтгэлээр туслан тэтгэж, улс төрийг бадруулах ба дорнод хязгаарт бүхий олон ядуу буурай улсыг туслах, тэтгэхийг хичээх ЗСБНХУ-тай найрамдлыг зузаатган, харилцан туслалцаж байгаа нь цөм маш зүйтэй бөгөөд их хэрэгт тавтай нийлэлцэх тул үүнээс хойш АЗГ-аас гадаадтай харилцах хэргийг энэ хэвээр бат нот болгон явуулж, хоёр улсын найрамдал ба ах дүүгийн барилдалгаа улмаар зузаатган бататгахад улсын ба эдийн засгийн тухай хоёр этгээдийн ашиг тусыг гол болгон шийтгэвэл зохино" гэжээ.<sup>29</sup>

### III. Монгол, Зөвлөлт Оросын хооронд байнгын элчин яамны харилцаа тогтсон нь

Монгол улсын Ардын Засгийн газар Зөвлөлийн засагт Орос улстай 1921 оны 11 дүгээр сарын 5-нд байгуулсан Найрамдлын гэрээний дөрөв, тавдугаар зүйлийг үндэслэн өөрийн улсын бүрэн эрхт элчин төлөөлөгчийг Москва хотноо томилон суулгах талаар ихээхэн анхаарал тавьж, Олноо өргөгдсөний 12 дугаар оны цагаан сарын 28 буюу европын 1922 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар уул асуудлыг хэлэлцээд Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Д.Бодоог Бүрэн эрх барих элчин төлөөлөгчөөр томилох шийдвэр анхлан гаргажээ. Тэр үед ЗОУ-д хэлэлцээр хийхээр Москвад очоод байсан Монголын төлөөлөгчдөөс ийм хүсэлт Засгийн газарт ирүүлсэн байжээ. Гэвч Д.Бодоо бие өвчтэй хэмээн чөлөө гуйсан учир Засгийн газрын мөн оны 3 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар энэ тухай хэлэлцээд оронд нь Цэргийн явдлын яамны дэд сайд Хатанбаатар дархан ван Магсаржавыг тохоон томилж, 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар ЭСЯ-ны орон тоог 8 хүний бүрэлдэхүүнтэй баталж өгчээ. Х.Магсаржав аанай л бие өвчтэй гэж мөн л чөлөө гуйжээ. Ингээд 3 дугаар сарын 29-ний хурлаар мэйрэн Жамсрангийн Давааг Бүрэн эрхт элчин сайдаар, Сангийн яамны дэд сайд Н.Жадамбааг зөвлөх түшмэлээр томилоод шалтгаан зааж, чөлөө мэдүүлж хэрхэвч үл болно гэсэн заалт гаргажээ.<sup>30</sup> Ингэж түшээ гүн Ж.Даваа Монгол улсаас ЗОУ-д суух анхны Бүрэн эрх барих Элчин төлөөлөгч болсон бөгөөд түүний итгэмжлэх жуух бичигт ГЯЯ-ны сайд хичээнгүй гүн Б.Цэрэндорж (Д.Бодоо 1922 оны 1 дүгээр сарын 7-нд өөрийн хүсэлтээр Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайдаас чөлөөлөгдсөн юм. Ерөнхий сайдаар Жалханз хутагт С.Дамдинбазар

томилогдсон билээ) 4 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурж ЗОУ-ын ГХА-ын комиссар Г.В.Чичеринд илгээсэн байна.

Элчин Ж.Даваа 1922 оны 5 дугаар сарын 22-нд Москва хотноо хүрэлцэн очжээ. Ирсэн даруйд элчин сайд, түшээ гүн Ж.Даваа албан хаагчдынхаа хамт Москвад хүрэлцэн ирснээ ГХАК-д мэдэгджээ. Орос улсын ГХАК-тын түшмэл Монголын элчин сайдын ирэх хугацааг урьдчилан мэдээгүйн улмаас хожимдсонд уучлал илэрхийлэж, төлөөлөгчдийг цахилгаан тэргэнд суулган тусгай бэлтгэсэн байранд буулгасан ажээ. Дараагийн өдөр ГХАК-тын Алс дорнодын хэлтсийн дарга С.И.Духовский, мөн яамны хамаарсан комиссар Л.М.Карахан хүлээн авч уулзсан байна. Элчин сайд Ж.Даваа АЗГ-аас илгээсэн бичгийг Л.М.Караханд барьж Засгийн газрынхаа өмнөөс найрамдлын үг хэлж, Монгол орны дотоод байдлын талаар товч танилцуулан харилцан ярилцсан байна. С.И.Духовский Ж.Даваатай уулзах үедээ доорх зүйлийг чухалчлан дурджээ. Үүнд: нэгд. Монголын асуудал, хоёрт. Дорнод Хятадын төмөр замын талаар хэмээн тайлбарлаж, энэ тухай Бээжинд суугаа элчин А.А.Иоффе дурдсан асуудлыг Хятадын талд тавьсан, харин Хятадын Засгийн газар Монголын асуудал бол манай дотоод хэрэг тул Орос улстай хэлэлцэх шаардлагагүй хэмээн зөвшөөрөөгүй татгалзсан болохыг дуулгажээ. Энэ тухай элчин сайд Ж.Даваа Нийслэл Хүрээнд яаралтай мэдээлжээ.

Ардын эрхт Монгол улсын элчин, түшээ гүн Ж.Даваа 1922 оны 6 дугаар сарын 2-нд ЗСБНХОУ-ын Бүх Оросын Төвийн Гүйцэтгэх Хорооны дарга М.И.Калининд итгэмжлэх жуух бичгээ барьж, дараа нь М.И.Калинин хорооны бусад гишүүд, нарийн бичгийн дарга зэрэг өндөр албаны хүмүүс хүлээн авч уулзжээ. Уулзалтанд элчингийн нарийн бичгийн дарга Н.Жадамбаа, хувьсгалт цэргийн дэд жанжин Х.Чойбалсан, цэргийн штабын дарга В.А.Хува нар оролцжээ.

“Монголын ард түмнийг үндэсний дарлалаас чөлөөлөхийн тулд Монгол, Оросын ард түмэн нийтийн дайсан Оросын цагаантны эсрэг явуулсан хамтын шударга тэмцлээр хоёр ард түмний хооронд үүсэн тогтсон ах дүүгийн гүн бат найрамдлын түүхэн ач холбогдлыг” бүрэн эрхт элчин Ж.Даваа тэмдэглэж, элчин төлөөлөгч нараа харилцан суулгаж байгаа нь тус хоёр орны хоорондын найрамдал, хамтын ажиллагаа бүх талаар гүнзгийрэн хөгжиж, бэхжиж зузаарахын нэг алхам мөн болохыг дурдаж зөвлөлтийн ард түмэн цаашид монголын ард түмэнд ах дүүгийн тусламж үзүүлсээр байна гэдэгт итгэж байгаагаа илэрхийлжээ. Дайны хөлд нэрвэгдсэн зөвлөлтийн ард түмэнд тус нэмэр болгохоор Монгол улс 1000 толгой үхэр бэлэглэх болсныг элчин Даваа М.И.Калининд энэ үеэр мэдэгдээд Найрамдлын хэлэлцээрийн үндсэн дээр Монгол, Зөвлөлтийн ард түмний хооронд эдийн засгийн болон бусад харилцаа хөгжиж бэхжинэ гэдэгт бүрэн итгэж байгаагаа илэрхийлжээ.

М.И.Калинин хариу хэлсэн үгэндээ, хоёр улс эрх тэгш хэлэлцээрийн үндсэн дээр элчин төлөөлөгч нараа солилцон суулгаж байгаа явдал нь уул хэлэлцээр амьдралд хэрэгжиж байгаагийн илрэл болохыг тэмдэглээд хоёр талын бүх талын харилцаа батжин хөгжинө гэдэгт бүрэн итгэж байгаагаа мэдэгдэж, эрх чөлөөгөө олсон Монголын ард түмэнд сайн сайхныг ерөөж, Зөвлөлтийн ард түмэнд үхэр сүрэг бэлэглэх болсон явдалд талархал илэрхийлсэн байна.<sup>31</sup>

Элчин сайд Ж.Даваа 1922 оны 6 дугаар 23-нд ГХА-ын комиссар Г.В.Чичеринд илгээсэн бичигтээ "...одоо Зөвлөлт Засагт Орос улсаас Монгол улсад суух Бүрэн эрх барих элчин сайдаа даруйхан томилон илгээж... нэг. ЗОУ-ын жинхэнэ элчин сайд Нийслэл Хүрээнээ одоод, гадаадын олон улстай ба ялангуяа дарлагдан зовсон бага улстай харилцан найрамдаж бүхий ёсоор Монгол улстай хэдэн зүйлийн чухал гэрээ байгуулбал Хятад, Япон, Америк улсын харгис үзэлтэн мэдэж ЗОУ-ыг урьдах Хаант засгийн үед явуулж байсан хэргийг орхихгүй хэмээн худал хэлэлцдэг нь дорно дахь Ази тивийн олон ардын нүдний өмнө илэрч, харин тэгж худал хэлдэг үг нь итгэгддэхгүй болно. Хоёр. Москва хотноо гэрээ тогтооход дорно зүгийн ард түмэнд эс мэдэгдэж, дээр дурдсан Орос, Монголын хоорондох тустай хэргүүд үл илэрнэ. Гурав. Нийслэл Хүрээнээ гэрээ хэлэлцэхээр тогтвол Монгол улсын бүх ард ...сонирхон, гадаад улстай гэрээ тогтоох явдлыг мэдэгдвэл Монгол улсад их тустай хэрэг болно..."<sup>32</sup> гэж дурджээ. ЗОУ-ын ГХА-ын комиссар Г.В.Чичерин хариу мэдэгдсэн бичигтээ "...Орос, Монголын хооронд цахилгаан мэдээ, шуудан бичиг, худалдаа арилжаа, банкны зэрэг гэрээнүүдийг ЗОУ-ын Засгийн газраас Хүрээнээ хэлэлцэхийг зөвшөөрөв".<sup>33</sup>

Тийнхүү 1922 оны 5 дугаар сард ЗОУ-ын ГХАК Монгол улсад суух бүрэн эрхт элчин төлөөлөгчөөр Николай Макарович Любарскийг томилсон учир тэрбээр мөн 7 дугаар сарын 7-нд Нийслэл Хүрээнд ирж ажилдаа оржээ.<sup>34</sup> Любавский Н.М. (1887-1937) 1918 он хүртэл Владивостокт Зөвлөлт засгийн хязгаарын Засгийн газрын гишүүн, 1918 оноос Швейцарьт Зөвлөлтийн Төлөөлөгчийн газарт нарийн бичгийн дарга, ГХАК-ын коллегийн гишүүн, Ярославын губернид ОК (б)Н, ТХШК-ын бүрэн эрхт төлөөлөгч, 1922-1923 онд Монголд бүрэн эрхт элчин төлөөлөгч, 1929 оноос Коминтерний системийн олон улсын ХАА-н институтэд хэвлэлийн эрхлэгч зэрэг ажил хийж байжээ.

Элчин сайд, түшээ гүн Ж.Даваад хоёр дахь удаагаа итгэмжлэх жуух барих хувь тохиосон юм. 1922 оны 12 дугаар сарын 30-нд Орос, Украин, Беларусь, Өвөр Кавказын Бүгд Найрамдах улсууд нэгдэж ЗСБНХУ байгуулагдсны дараа 1924 оны 1 дүгээр сарын 11-нд ЗСБНХУ-ын Төвийн гүйцэтгэх хорооны тэргүүлэгчдийн дарга М.И.Калининд итгэмжлэх жуух бичгээ барьснаар түшээ гүн Ж.Даваа мөн л ЗСБНХУ-д Монгол улсаас суусан анхны элчин сайд болсон ажээ.<sup>35</sup>

Жамсрангийн Даваа нь 1873 онд Сэцэн хан аймгийн Эрдэнэ вангийн хошуу, одоогийн Дорнод аймгийн Буйр гэдэг газар төржээ. Бага наснаасаа монгол бичигт суралцаж, идэр наснаасаа манж, түвд хэл сурч харьяат хошууны тамгын газарт тал, жинхэнэ бичээчийн ажил хийж явжээ. 1921 оны 3 дугаар сарын 17-нд АТЗГ Сэцэн хан аймгийн Эрдэнэ вангийн хошууны мэйрэн Ж.Давааг ГЯЯ-нд туслах түшмэлээр томилсон байна. 1922 оны 3 дугаар сард Богд хаанаар зөвшөөрүүлсэн Засгийн газрын 7 дугаар хурлын 5 дугаар зүйлээр хэлэлцэж Ж.Давааг Зөвлөлт Орост суух бүрэн эрх барих элчин сайдаар томилон дүрмийн ёсоор түшээ гүнгийн хэргэмээр шагнажээ. 1924 оны 10 дугаар сард өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөгдсөн байна. Ж.Даваа 1926 оны 8 дугаар сард Улаанбаатар хотноо Монгол-Тагна Тувагийн хооронд Найрамдлын гэрээ бичиг байгуулах, 1935-1936 оны Монгол-Манж-Го-гийн хилийн хэлэлцээнд оролцож, дараа нь ГЯЯ-нд бичиг хэргийн эрхлэгчээр ажиллаж гадаад бодлогыг улс төрийн арга хэлбэрт оруулах ажилд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Ж.Даваа нутагтаа амьдарч байгаад 1942 онд насан эцэслэжээ. Түүний халааг МАХН-ын дарга япон буюу Баатуд овогт Ажваан Данзан (1924-1925), түүхч, манжч, Бүх цэргийн бэлтгэлийн хорооны дарга гүн Бүрдийн Буянчуулган (1925-1926) 1927-1929 онд ГЯЯ-ны орлогч сайд байсан, мөн 1921-1922 онд МХЗЭ-ийн анхны дарга, 1923 оноос ГЯЯ-ны хэлтсийн дарга, ЗХУ дахь Монгол улсын ЭСЯ-ны хэлмэрч, I, II нарийн бичгийн дарга, элчингийн үүрэг гүйцэтгэгч, Москвагийн Хууль цаазын дээд сургууль дүүргэсэн Цээжид овогт Ганжуурын Гүрсэд (1927-1928) нар томилогдон үргэлжлүүлсэн юм. Г.Гүрсэд 1929-1930 онд ГЯЯ-ны сайдын албыг хашиж байсан билээ. 1929 онд Москвад элчингээр Дуламжавын Гомбожав ажиллаж байв.

1923 оны 12 дугаар 30-нд ЗСБНХУ-ын элчин сайд Алексей Николаевич Васильев Монгол улсын нийслэлд хүрэлцэн ирж, 1924 оны 1 дүгээр сарын 3-нд АЗГ-ын тэргүүн Б.Цэрэндоржид итгэмжлэх жуух бичгээ барьжээ. Элчин сайдыг хүлээн авахад МАН-ын ТХ-ны зарим тэргүүлэгч гишүүд оролцож, хоёр орны ард түмний ах дүүгийн найрамдлыг нандинаар бэхжүүлэхийн бэлэг тэмдэг болгож, түүнд улаан хадаг хүндэтгэн барьж цаашдын ажил үйлсэд нь амжилт хүсэн ерөөсөн байна.<sup>36</sup> Элчин сайд А.Н.Васильевийг ажил хэргээ эхлүүлсэнтэй нь холбогдуулан хоёр ард түмний найрамдлын энэрэнгүй үзэл санааны илрэл болгож, АЗГ 1 дүгээр сарын 1-нд хоригдож байсан Зөвлөлтийн харьяат нарт өршөөл үзүүлж суллан гаргажээ. Түүний орыг 1925-1927 онд Петр Николаевич Никифоров, 1927-1933 онд Андрей Яковлевич Охтин нар үргэлжлүүлсэн билээ.

Хоёр орны хооронд ийнхүү элчин төлөөлөгчийн хэмжээнд харилцаа тогтсон хөгжсөн нь Монгол улс тусгаар бүрэн эрхт улс мөнийг дахин нотолсон хэрэг байв.



**ИШЛЭЛ, ЗҮҮЛТ**

1. М.Санждорж. “Ардын төрийн түүх”. УБ, 1974, 24 дэх тал
2. Мөн тэнд
3. Мөн тэнд
4. ГХТА. Ф-01. т-1100
5. ГХТА. Ф-01. ш-1173
6. ГХТА. Ф-01. хн-247
7. ГХТА. Ф-01. хн-315
8. ГХТА. Ф-01. хн-66
9. Мөн тэнд
10. ГХЯ-ны консулын газрын лавлах. УБ, 1978
11. Мөн тэнд
12. С.Ш.Нацов. “Западная Монголия”. Новый восток. Кн. IV. №4. 1923, с.157
13. Кунгуров и И.Сороковиков. Аратская революция. Иркутск, с.165
14. Robert A.Rupen. The Mongols of the Twentieth Century. Bloomington. 1964, p.184
15. Ц.Дамбадорж. “Толбо нуур”. УБ, 1964
16. “МАХН-ын түүхийн зарим чухал заалтууд /1920-1924/”. УБ, 1946, 64-65 дахь тал
17. Лузянин С.Г. Россия-Монголия-Китай в первый половина XX века. М, 2000, с.20
18. Х.Чойбалсан, Л.Лосол, Г.Дэмид. Монгол ардын хувьсгалын анх үссч байгуулагдсан товч түүх. УБ, 1979, 95 дахь тал
19. Л.Бат-Очир. “Бодоо сайд: үзэл ба үйлс”. УБ, 1991, 34 дэх тал
20. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхэтгэл. 1 боть, УБ, 1964, 5 дахь тал
21. газ: “Красный стрелок” №105 /563/ 7 июнь 1921 г.
22. НТА. Ф-1. Ф-Т-1. хн-12
23. Д.Даш. “Б.З.Шумяцкий”. УБ, 1987, 101 дэх тал
24. БНМАУ-ын гадаад харилцаа. 1 боть, 31-32 дахь тал.
25. НТА. Ф-12. Д-1. хн-20
26. Лузянин С.Г. 20 дахь тал
27. газ: “Известия” №250 /1393/ 6 ноября 1921
28. ГХТА. Ф-1. т-5, хн-91
29. “УИХ-ын сонин” тэргүүн дэвтэр. 1924, 52 дахь тал.
30. УТТА. Ф-1. д-1. хн-72
31. “Известия” №-123. 4 июнь 1922
32. НТА. Ф-1. т-24. хн-62
33. Мөн тэнд
34. “Годовой отчёт за 1923 г. Народного комиссариата по иностранным делам II съезду советов СССР”. с.152
35. “Известия” №10 /2045/ 12 января 1924.
36. “Нийслэлийн шинэ сонин” №22, 1924-1-8